

## ТАНИЛЦУУЛГА

### *Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл*

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт улсын бүртгэлийн үйл ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, “Нэг иргэн, нэг бүртгэл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар бүртгэлийн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлэх, бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй бөгөөд ил тод, нээлттэй болгох чиглэлээр одоо үйлчилж буй эрх зүйн орчныг сайжруулах, олон улсын чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгох зорилтыг дэвшүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий хууль нь 2009 онд батлагдсан, 5 бүлэг, 22 зүйлтэй. Уг хуульд батлагдсанаас хойш 3 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр нийт 9 зүйл, заалтад өөрчлөлт орсон. Энэ удаагийн шинэчилсэн найруулгын төслөөр зарчмын шинжтэй өөрчлөлтүүд орсноос гадна хуулийн нийт зүйл, заалтын талаас илүү хувьд буюу 15 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 15.8-д заасны дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараахь өөрчлөлтийг тусгасан болно:

1. Энэ хуулиар улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо, байгууллагын чиг үүрэг, удирдлагын бүрэн эрх, үйл ажиллагааны хяналт, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн төрлүүд, мэдээллийн сантай холбоотой харилцааг зохицуулдаг тул хуулийн зорилтыг илүү нарийвчлан тодорхойллоо.

2. Хуульд хэрэглэгдэж байгаа зарим ойлголт, нэр томъёог нийтэд ойлгомжтой болгох, илүү нарийвчлан тодорхойлох зайлшгүй шаардлагын улмаас хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолтыг тусгайлан зүйл болгож орууллаа.

3. Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн төрлүүдийг холбогдох хууль тогтоомжуудад нийцүүлэн шинэчлэн тогтоох бөгөөд цахим иргэний үнэмлэхийн хэрэглээг нэмэгдүүлж, иргэний хувийн мэдээллийг иргэний үнэмлэхийн санах ойд тэмдэглэхээр тусгах, уг мэдээллийг ашиглан хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хийхэд ашиглах, иргэний үнэмлэхийг ашиглан төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаас үйлчилгээ авах боломжтой байх, иргэний үнэмлэхийг бусдад шилжүүлэх, барьцаалах, санаатайгаар гэмтээх, хууль бусаар ашиглах, хуурамчаар үйлдэхийг хориглох зэрэг суурь зохицуулалтыг тусгана.

4. Хуулиас дээгүүр болзол шаардлагыг дүрэм, журмаар тогтоохоос татгалзаж улсын бүртгэлийн суурь харилцааг хуулийн хүрээнд илүү тодорхой, нийтэд ойлгомжтой байдлаар зохицуулах шаардлага байгаа тул улсын бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт, улсын байцаагчийн хэрэгжүүлэх эрх, үүрэг, байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, удирдлагын бүрэн эрхийн талаар холбогдох өөрчлөлтүүдийг орууллаа.

Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 173 дугаар тогтоолоор баталсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын дүрэм, 2010 оны 47 дугаар

тогтоолоор баталсан Улсын бүртгэлийн хяналтын дүрмийн холбогдох суурь зохицуулалтыг хуулийн төсөлд тусган нарийвчлан тогтоолоо.

5. Бүртгэлийн мэдээллийн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал болон мэдээллийн технологийн хэрэглээг сайжруулах чиглэлээр холбогдох өөрчлөлтүүдийг тусгалаа.

Үүнд цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, оруулах, Үндэсний дата төвд улсын бүртгэлийн мэдээллийн санг хадгалуулах, тус төвөөр дамжуулан мэдээллийг бусад байгууллагатай солилцох боломжтой байх, сангийн хадгалалт, хамгаалалтын чиглэлээр мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгжийн хүлээх эрх, үүрэг болон иргэн, хуулийн этгээдэд мэдээллийн сангаас ашиглуулах мэдээллийн төрөл зэргийг нарийвчлан тогтоолоо. Мөн улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь мэдээлэл нь цаасан эх хувьтай адил байхаар төсөлд тусгасан.

6. Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас иргэн, хуулийн этгээдэд өгөх бүртгэлийн мэдээллийн нээлттэй байдал болон хувь хүний нууцын хамгаалалтын тэнцвэртэй байдлыг хангах, хуулийн этгээд болон хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийг нээлттэй болгож олон улсын жишигт нийцүүлэх, зах зээлд оролцогчдыг үнэн зөв мэдээллээр хангах, хөрөнгийн эдийн засгийн эргэлт, өсөлтийг дэмжих замаар олон нийтийн болон татварын хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзэн хуулиар хориглосноос бусад бүртгэлийн мэдээллийг нээлттэй ашиглуулах, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр өгөх мэдээллийг ангилан зааж мэдээлэл өгөх журмыг хуулиар тогтоохоор тусгалаа.

Одоо байгаа эрх зүйн зохицуулалтаар иргэн, хуулийн этгээдэд нээлттэй, хаалттай, хязгаартайгаар өгөх улсын бүртгэлийн мэдээллийг ангилан заагаагүй буюу тодорхойгүй, ихэнх тохиолдолд мэдээлэл нь хаалттай байдгаас иргэд бүртгэлийн байгууллагад зайлшгүй биечлэн ирж үйлчлүүлэх шаардлага үүсдэг. Бүртгэлийн байгууллагаас гаргасан тоон мэдээллээр иргэн, хуулийн этгээдэд 2014-2016 оны эхний 10 сарын байдлаар нийт 177 мянга гаруй хуулбар, лавлагааг архивын баримтаас хуулбар хийн цаасан хэлбэрээр болон үнэт цаасаар олгожээ.

Энэ нь иргэдэд төдийгүй бүртгэлийн байгууллагад цаг хугацаа алдах, ажлын ачаалал, зардал нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болдог тул улсын бүртгэлийн мэдээллийн сангаас цахим хэлбэрээр олгох мэдээлэл, лавлагааны үйлчилгээг сайжруулах, иргэд хуулиар зөвшөөрсөн мэдээллийг чирэгдэлгүй, хүртээмжтэйгээр, чөлөөтэй ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Ингэснээр төрийн байгууллагад үзүүлэх ачааллыг бууруулахын зэрэгцээ улсын төсөв бүрдүүлэлтийг нэмэгдүүлнэ. Улсын бүртгэлийн байгууллагаас төрийн үйлчилгээний цахим машины лавлагаанд зориулж жилд 1070000 үнэт цаас хэвлүүлж үйлчилгээний хөлсний хэмжээг 1000 төгрөгөөр тооцон лавлагаа, мэдээллийг олгодог бөгөөд нийт 1 тэрбум 70 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлдэг. Эрх зүйн орчин сайжирснаар энэ төрлийн үйлчилгээнээс улсын төсөвт орох орлого нэмэгдэнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар дараахь эерэг үр дагавар бий болно гэж үзэж байна:

1.Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг нарийвчлан зохицуулснаар мэдээллийн аюулгүй байдал сайжирч, иргэд шуурхай, чирэгдэлгүйгээр цахим үйлчилгээ авах эрх зүйн орчин бүрдэнэ.

2.Улсын бүртгэлийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар улсын байцаагчийн эрх, үүргийг тодруулж холбогдох суурь зохицуулалтыг оруулснаар улсын бүртгэлийн аливаа зөрчил, алдаа дутагдлаас сэргийлэх нөхцөл бүрдэх бөгөөд бүртгэлийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирна.

3.Хуулиар хориглосон буюу хязгаарласнаас бусад мэдээллийг нээлттэй болгож, иргэн, хуулийн этгээдийг бүртгэлийн үнэн зөв, бодитой мэдээллээр хангах, илүү ойлгомжтой бүртгэлийн үйлчилгээг иргэдэд санал болгох бөгөөд үүнийг дагаад улсын бүртгэлийн байгууллагад хандаж цахим хэлбэрээр мэдээлэл, лавлагаа авах иргэн, хуулийн этгээдийн тоо өсөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж залилан, бусдын эд хөрөнгийг завших зэрэг эдийн засгийн гэмт хэргийн гаралт багасах ач холбогдолтой юм.

4.Бүртгэлийн суурь харилцааг хуулийн хүрээнд илүү тодорхой, ойлгомжтой байдлаар зохицуулж хуулиас дээгүүр болзол шаардлагыг дүрэм, журмаар тогтоохоос татгалзаж хуульд нийцсэн байх зарчим үйлчилнэ.

5.Хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчил арилна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан иргэний бүртгэлийн мэдээллийн сангаас эд хөрөнгийн зарим төрлийн эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэх талаар Иргэний хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах болно.